

Монгол хөөмийн урын сангийн онцлог

Эрдэнэцогтын Дүүриймаа 

Соёл урлагийн их сургуулийн харьяа Соёл, урлаг судлалын хүрээлэн,
Улаанбаатар, Монгол Улс
✉ duuriimaa.e@mnuac.edu.mn

Хураангуй: Монголчуудын байгаль, нийгэм, ахуй амьдралын онцлогоос үүдэлтэй язгуур соёл, ардын урлагийн өвөрмөц нэгэн төрөл зүйл бол хөөмий юм. Хөөмийлөхүйн үйл нь эрт цагаас монголчуудын зан үйл, мал ахуй хийгээд байгаль дэлхийтэй харилцах дохио хэл бүхий харилцааны нэгэн хэрэглүүр болж ирсэн онцлогтой. Байгаль, дэлхий, мал ахуй, араатан жигүүртэн зэрэг сав шимийн ертөнцийн мөн чанарыг таних, аргадан дээдлэх, амьдрах арга ухаанаас хөөмийн үйл үүдэж, түүний мөн чанарын илрэл нь хүний дуу хоолойгоор амилан биежиж ирсний бодит тусгал нь хөөмийн урын сан юм.

Иймээс хөөмийн урын сангийн онцлогийг тодорхой түүхэн цаг үед хамаатуулан авч үзэж, төлөөлөх уран бүтээлчдийн урын сангийн онцлог, хөөмийн уран бүтээлийн сэдэв, тоглох арга техник, хэв маяг болон соёлын үүрэг, ач холбогдол, хөгжлийн чиг хандлага зэргийг тус өгүүлэлд тодруулахыг зорив. Монголчууд хөөмийн өвөрмөц авиа эгшиг, ая аялгуугаар монгол соёлын нэгэн тэмдэг, дохио, утга бэлгэдэл, дүр дүрслэл, ертөнцийг үзэх үзэл, оюун санааны үнэт зүйлсийн давтагдашгүй утга агуулга бүхийн урын санг бүтээжээ.

Түлхүүр үгс: аман өв, зан үйл, сүсэг бишрэл, бүтээл, хамтлаг, гоцлол

Features of the Mongolian throat singing repertoire

Duuriimaa Erdenetsogt 

The Research Institute of Culture and Arts, Mongolian National University
Of Arts and Culture, Ulaanbaatar Mongolia
✉ duuriimaa.e@mnuac.edu.mn

Abstract: In addition to the nature, society, and lifestyle of Mongolia, a unique form of folk art and culture is the Mongolian throat singing (khöömii). Mongolian throat singing has been a traditional Mongolian ritual since ancient times, and has become a means of communication through animal husbandry and nature. Therefore, the characteristics of the Mongolian throat singing repertoire were examined in relation to a specific historical period.

Mongolians have created a unique repertoire of throat singing, a symbol, sign, meaning, imagery, mentality, and spiritual values, with unique sounds and melodies of throat singing.

Keywords: *oral tradition, ritual, devotion, creation, ensemble, solo*

Оршил

Урын сан бол аливаа хүн төрөлхтөн, үндэстэн, угсаатны оюун сэтгэлгээний өвөрмөц онцлогийг илтгэсэн соёл, урлаг, уран сайхны үйл ажиллагааны цогцолбор өв, сан юм. Тэрхүү баялаг сангаар тухайн ард түмний соёл, гоо сайхны сэтгэлгээ, ухамсар, мэдлэг ухаан зэрэг язгуур үнэт зүйлс илрэн хөгжиж ирсэн байдаг. Урын сан (repertory) хэмээх ойлголт XVI зууны дунд үеэс эхлэлтэй бөгөөд *reperire* буюу “олсон, илрүүлсэн” гэсэн үйл үгийн язгуур болох *reper* хэмээх латин үгээс гаралтай. Хожим латин хэлний “*repertorium*” буюу “*бариа материал*”, франц хэлний *répertoire* буюу “*хийж чадах бүхий л зүйл*” гэсэн утгаас эх авч “*repertory*” нь тогтмол тоглодог хамт олон, жүжигчдийн тоглолтууд гэсэн утгаар англи хэлнээ бичиж, тэмдэглэгдэж иржээ. Өөрөөр хэлбэл, урын сан гэдэг нь тухайн хувь хүн, уран бүтээлч эсвэл бүлэг хамт олон, театрын уран бүтээлчдийн бүтээн туурвисан нөөц, сан юм. *Урын сан* хэмээх үгийн утгыг мөшгөн үзвэл, “Монгол хэлний их тайлбар толь”-д “*уран сайхны өв, хуримтлал*”¹ гэж тайлбарласан бол, хөгжим судлаач Н.Жанцанноров, “Репертуар буюу “урын сан” гэдэг нь дуучин, хөгжимчин, дуу хөгжмийн сургууль, байгууллагад уран сайхны хэрэглэгдэхүүн болж байгаа дуу хөгжмийн бүтээл” (Жанцанноров 1996, 80) гэж тайлбарласан байна. Мөн “уран бүтээлч, эвлэл холбоод, бүх ард түмний урлан туурвисан бүтээлийн сан хөмрөг...” (Батчулуун 2018, 718) зэргээр тэмдэглэгджээ. Эдгээрээс үзэхэд, урын сан гэдэг ойлголт бол тухайн бие хүн хийгээд бүлэг хүмүүсийн оюун сэтгэлгээний үнэт зүйлийн цогцолбор өв сан болж буй хэрэг юм. Энэхүү уран сайхны цогцолбор өв санг нарийвчлан үзвэл, тухайн үндэстэн, угсаатан, ард түмний хэл, зан үйл, шашин шүтлэг, ёс заншил гэх мэт оюун санааны үнэт зүйлийн хэмжүүр, илэрхийлэх соёлын ялгамж (identity) нь болж байдаг онцлогтой.

Монгол хөөмийн судалгаа 1970-аад оны сүүл үеэс эхэлсэн бөгөөд францын эрдэмтэн Тран Куан Хай, английн эрдэмтэн Кароль Пегг, италийн эрдэмтэн Пьеро Коси нарын судлаачид монгол хөөмийн акустик болон тува хөөмийтэй харьцуулсан судалгааг хийсэн нь олон улсад хөөмий судлалыг таниулах чухал эхлэл болсон. Энэ цаг үеэс монгол хөөмийчдийн хөөмийлөх арга барил, ур чадвар дотоод, гадаадын эрдэмтэд, угсаатны хөгжим судлаачдын анхаарлын төвд орж, судлаачдын олон арван судалгааны объект болж ирсэн. Эдүгээ хөөмийн урын санд тулгуурласан, тэр дундаа хөөмийг соёлын зан үйлийн үүднээс авч үзэж зан үйлээсээ улбаалсан урын санг бүтээж ирсэн тухай эрдэм шинжилгээний судалгаа, бичвэр хараахан гараагүй байна. Энэхүү судалгааг хийснээр монгол хөөмийн урын сангийн хөгжил, уламжлалыг соёлын түүхэн хөгжлийн үүднээс авч үзэж, зан үйлийн

¹ Монгол хэлний их тайлбар толь. “Урын сан” 2025.04.01. <https://mongoltoli.mn/dictionary/detail/76342>

нарийн нийлэмжээс бүрэлдэн тогтсон болохыг соёлын зарим онолын үүднээс тайлан тайлбарлаж илрүүлэн судлах шинжлэх ухааны ач холбогдолтой хэмээн үзэж байна. Хөөмийг эртнээс монголчуудын бүтээсэн язгуур урлагийн хүрээнд өгүүлэхүйн эрхтний шүтэлцээт урлаг хэмээн авч үзэж ирсэн. Нөгөө талаас хөөмий нь монголчуудын ахуй амьдралаас үүдэж гарсан зан үйлийн соёлтой салшгүй холбоотой. Энэ нь байгаль, дэлхий, уул усыг аргадан дээдлэх зан үйл, малын уриа дуудлага, хүн өөрийгөө танин мэдэх, баясгах, сэтгэлийн таашаал эдлэх зэрэг хүн-байгаль, хүн-мал ахуй, араатан жигүүртэн, хүн-хүнтэй харилцах арга ухаанаас үүдсэн соёлын илрэлүүд юм. Иймээс хөөмий бол дан ганц урлагийн төрөл хэлбэр төдий бус монголчуудын соёл илэрхийлэл, зан үйлийн шинж бүхий соёлын биет бус өв юм. Хөөмийг урлаг судлал, тэр дундаа угсаатны хөгжим судлалын үүднээс гадаад, дотоодын цөөнгүй эрдэмтэд судалснаас монгол хөөмийн урын сангийн онцлог, урын сан бүрэлдэхэд нөлөөлсөн нийгэм, соёлын хүчин зүйлийн талаар судалсан дорвитой судалгаа хийгдээгүй байна. Үүнийг хэрэглээний соёл судлалын онол болон төрөл зүйлчлэл (типологи), соёлын бүтэц, үүргийн онолын үүднээс шинжлэх, язгуур соёлын өвийн урын сангийн онцлогийг судлан тодруулах чухал шаардлагатай юм. Тэр дундаа түүхэн хөгжлийн явц дахь нийгмийн хүчин зүйлсээс хамаарч хөөмийн уран бүтээлийн туурвил, сэдэв, тоглох арга техник, төлөөлөх уран бүтээлчдийн урын сан хэрхэн хөгжиж ирсэн зэргийг гаргахыг зорьсон нь тус өгүүллийн шинэлэг хийгээд ач холбогдолтой тал болно.

Урын сангийн тухай ярихаас өмнө уран бүтээл, урлан бүтээхүйн тухай цухас дурдах нь зүйн хэрэг юм. Уран бүтээл гэдэг нь нэг талаас аливаа хүмүүний мөн чанар дахь билиг авьяас, бүтээлч сэтгэлгээний үйл илрэн биежих хэлбэр, нөгөө талаас уран сайхны аргаар бүтээгдсэн туурвил гэж хэлж болно. Уран бүтээл бий болох болон урлан бүтээх, урлан бүтээхүйн сэтгэл зүйн талаар өрнө дахины сэтгэгчид өнгөрсөн зуунд янз бүрийн үзэл баримтлал, тодорхойлолтуудыг дэвшүүлсээр ирсэн. Тухайлбал, идеалист онолчид “...урлан бүтээхүйн сэтгэл зүй нь уран бүтээлийг зөвхөн сонгомол хүмүүст хүртээлтэй, тайлбарлашгүй үзэгдэл.., уран бүтээлд хөдөлмөрийн аливаа үүрэг, ер ямар нэгэн үйл ажиллагаа, түүний дотор сэтгэхүйн үүргийг үгүйсгэж, тайлбарлагдамгүй, ухамсаргүй ажлын үр дүнд шинэ зүйл аяндаа бүтээгдэнэ” (Балхаажав ба бус. 1990, 429) гэж үзэж байв. Харин энэхүү санааг материалист онолчид уран бүтээл бол хөгжсөн хэлбэрээрээ хөдөлмөрийн үр дүн юм хэмээн үзэж идеалистуудын санааг үгүйсгэдэг. Өөрөөр хэлбэл, уран бүтээлийн үйл ажиллагааны сэдэл, зорилго нь нийгмийн хэрэгцээнээс төрөн гарна гэсэн үзэл баримтлалыг гол болгож байв. Урлан бүтээхүй, бүтээн туурвих гэдэг нь соёлын тухай ойлголтод зүй ёсоор хамаарна. Дээрх үзэл баримтлал нь соёлын хүн судлаач Б.Малиновскийн “Соёлын функцийн онол” (*cultural function*) дахь “Хэрэгцээний онол” (*theory of needs*) -той агуулгын хувьд ихээхэн ойролцоо дүйж байгаа юм. Тэрээр энэ тухай “...хувь хүний биологи, физиологи, нийгмийн хэрэгцээг хангах гэж соёл оршдог” (Бум-Очир ба Мөнх-Эрдэнэ 2012, 91) гэж үзсэн. Өөрөөр хэлбэл, зан үйлийг соёлын үүрэг, үйл ажиллагааны нэг чухал илрэл хэмээн авч үзсэн байдаг. Иймд зан үйл бол бэлгэдлийн салшгүй нэг хэсэг болохын сацуу хүмүүний оюун санаанд орших сүсэг бишрэл, ёс суртахуун, харилцааны чухал хэм хэмжээ болсоор иржээ. Тухайлбал, зан үйл (*ritual*) гэдэг

бол дом (*магия*)-той салшгүй холбоотой бөгөөд зан үйл нь домдоо захирагдана гэж Малиновский үзсэн (Андреева 2018, 83). Өөрөөр хэлбэл, хүнээс ангид зан үйл, зан үйлээс ангид хүн үгүй зан үйл нь соёлын анхдагч нөхцөл бөгөөд энэ нь урлагтай салшгүй холбоотой юм. Ингэж үзвэл, ардын язгуур соёл, соёлын өв тэр дундаа хөөмийн урлаг нь монголчуудын байгаль, биологи, оюун санааны хэрэгцээнээс урган гарахын сацуу нийгмийн оюуны хэрэгцээг хангаж буй соёл, зан үйлийн илрэл юм. Хөөмийн урлагийг байгаль, хүрээлэн буй орчноос шууд хамааралтай, динамик шинж чанар бүхий системлэг соёлын өв гэж үзэж болно. Тэгвэл монгол хөөмий нь “урлаг” хэмээх төрөлд хамаарахаасаа өмнө монголчуудын амьдралын хэв маягаас үүдсэн соёлын хэлбэр, үйл ажиллагаа, тэмдэг дохио бүхий зан үйл байсан байна. Аажимдаа уран сайхны хэлбэр, төрхийг олж хөгжиж, эдүгээ язгуур урлагийн төрөл жанр болж бүрэлдэн тогтсон байх бүрэн үндэслэлтэй юм.

Эртний грекийн философич Платон, Аристотель нарын дэвшүүлсэн, “Урлагийн дуурайхуйн онол” (*Mimetic Theory of Art*)-д урлаг нь байгалийг даган дуурайхуйн үйл явц юм. Энэ нь байгалийг шууд хуулбарлан дуурайх гэсэн үг бас биш. Хуулбарлах гэхээсээ илүүтэй “дахин дүрслэх, таниулах (later a representation) гэсэн утга санаанд илүү дүйж байна (Aristotle, *Mimetic Theory of art*) гэж үзсэн. Тэрээр уран зураг бол харааны үзэгдлийг, уран баримал нь гурван хэмжээст объектыг, жүжиг нь хүмүүнээс илрэх зан чанарыг дуурайж хийгддэг учир урлаг тэр чигтээ дуурайхуйн мөн чанарт дулдуйддаг хэмээн үзсэн. Дээрх онолын үүднээс авч үзвэл, хөөмий нь монголчуудын байгалийг даган дуурайх, хөгжимлөг сэтгэлгээнээс үүдэж үүссэн урлагийн биеэ даасан нэгэн төрөл хэлбэр юм.


Энэхүү даган дуурайх сэдэл, сэтгэлгээ нь монголчуудын хувьд зүгээр ч нэг бий болсон зүйл биш юм. Дөрвөн цагийн эргэлтэд нүүдэллэн аж төрж, мал ахуйгаа адгуулж, байгальдаа зохирон амьдарч ирсэн малч удамт монголчуудын хувьд байгалийг шүтэн дээдлэх үзэл өндөр байр суурьтай. Иймээс байгалийг даган дуурайх хандлага нь эхэн үедээ байгаль дэлхийг амьшуулан үзэх, байгалийн гэнэтийн үзэгдлээс эмээх, түүнд орших эзэн савдгийг аргадан тайтгаруулах, тэмдэг дохио, утга бэлгэдэл, зан үйлийн шинжтэйгээр үүсэж дэлгэрээд улмаар эдүгээ урлагийн төрөл хэлбэрийн хэв шинжийг бий болгосон байх бүрэн боломжтой хэмээн үзэж байна. Тэгэхээр урлаг бол зан үйлээсээ, зан үйл нь урлагаасаа ангид үл орших бөгөөд өөр хоорондоо нарийн нийлэмжээр харилцан сүлэлдэж оршдог онцлогтой.

Тийм ч учраас монгол хөөмийн дахин давтагдашгүй өвөрмөц чанар, өвлөн уламжлагчдын ур авьяас, монголчуудын бүтээсэн өв соёлыг үнэлэн Дэлхийн биет бус соёлын өвийн жагсаалтад бүртгэсэн билээ. Хөөмийлөхүйн үйл бол амьсгалын тусламжтай бүтээгддэг бөгөөд энэ нь тухайн хүний дотоод мэдрэмж, сэтгэлгээ, сэтгэл зүйн байдалтай нарийн хамааралтай. Үүнээс үүдэж хөөмийн урлагийг хүн хөгжим, сэтгэлгээний урлаг гэхчлэн онцолж нэрлэн томьёолдог. Өөрийн дотоод мөн чанар, сэтгэмж, ертөнцийг үзэх үзэл санаагаа уран зураг, уран зохиол, яруу найраг, хөгжим, дуу, бүжиг зэрэг урлагийн бүтээлээр дамжуулан илэрхийлдэг. Тэрхүү урлаг, уран сайхны бүтээл, туурвил нь урын сан хэмээх өв санг бүрдүүлдэг. Аливаа ард түмэн, үндэстэн угсаатны соёл сэтгэлгээний онцлогийг тэдний олон зуун жилийн туршид бүтээсэн өв, уламжлал, уран бүтээлүүдийн урын сангаар

дамжуулан ойлгож, танин мэдэж, тайлж болдог. Иймээс хүмүүний чинадын мөн чанараас илрэх утга санаа, сэтгэлгээний үнэт зүйл бол яах аргагүй хөөмийн урын сан билээ. Хөөмийн урын сан нь монголчуудын байгаль, мал ахуйтай харилцах харилцааны утга санаа, хорвоо ертөнцийг танин мэдэх, чимээлэх, даган дуурайх, тэдгээртэй харилцах арга ухаан, зан үйлийн шинжээр илрэн хөгжиж уламжлагддагаар онцлог юм.

Судалгааны арга зүй

Монгол хөөмийн урын сангийн асуудлыг тодруулахын тулд монгол хөөмий үүсэж хөгжих байгаль, нийгэм, соёлын орчны нөлөөг зураг 1-т үзүүлснээр судлан тодорхойлохыг зорив. Чингэхдээ, *нэгдүгээрт*, Хөөмийн хөгжлийн эхэн үе (нэн эрт цаг үеэс XX зуун хүртэлх), *хоёрдугаарт*, Монгол хөөмийн хэв шинж бүрэлдэн тогтсон цаг үе (XX зууны дунд үеэс XX зууны эхэн үе хүртэлх) үүнд, *нэгд*, язгуур хэв маягаа хадгалан хөгжсөн цаг үе, *хоёрт*, язгуур хэв маягаас орчин үеийн хэв маягт шилжсэн цаг үе хэмээн ангилан авч үзэв.



Зураг 1. Монгол хөөмийн урын сан үүсэж хөгжих байгаль, нийгэм, соёлын орчны нөлөө

Энэхүү ангиллын хүрээнд хөөмийн уран бүтээлчдийн бүтээлийг төрөл, дуугарах арга техникийн онцлогоор шинжлэн үзсэн бөгөөд хөгжлийн эхэн үеийн хүний оюун санаа, утга бэлгэдлээс урган гарсан зан үйлийн холбогдолтой бүтээлүүд өнөө цагт ч уламжлагдан ирсэн нь араатан жигүүртэн, мал ахуйг аргадах, тойглон төл авхуулах, газар тэнгэр, уул усыг аргадан тахиx үйл бүхий уран бүтээлүүд шууд хамаарч байна. Иймээс бид дээрх судалгааны хүрээнд, аман сурвалжилга (interview), түүхэн зүй (historical), Эртний грекийн философич Платон, Аристотель нарын дэвшүүлсэн “Дуурайхуйн онол” (Mimetic theory), Малиновскийн буюу “Хэрэгцээний онол” (Needs of theory)-ын үзэл баримтлалыг суурь онол арга зүйгээ болгож тус судалгааг гүйцэтгэв.

Хөөмийн урлаг, дуу авиа, ая эгшиг чухам хэдий үеэс үүсэж бий болсон нь тодорхойгүй ч яагаад, хэрхэн хөөмийлдөг, яах гэж хөөмийлдөг байсан зэрэгт ихээхэн сонирхолтой бөгөөд олон янзын хариулт, учир шалтгааны таамаглалууд бий болсон нь ажиглагдана. Энэ үүднээс авч үзвэл, хүмүүс хоорондоо ойлголцох тэмдэг дохио, дуу авиаг илэрхийлэх зэрэг харилцааны хэлбэрүүд үүсэж хөгжсөн цаг үетэй холбон тайлбарлах шаардлагатай. Польшийн хэл шинжээч Бодуэн де Куртенэ 1913 онд хэл ярианы үүслийн тухай Дин-Дон (Ding-Dong Theory) (Courtenay 2024) хэмээх онолыг гаргаж ирсэн бөгөөд онолдоо, “хүний хамгийн эртний хэл нь байгалийн дуу чимээ, амьтдын дуугарах дуу авиа зэргээр нь утгачилж (onomatopoeia) нэрлэдэг дуу авианууд байсан байж болно” (Tatiana, Some of the theories about how emerged...) гэж үзсэн. Мөн өмнөд африкийн их сургуулийн профессор Жорж Пулос хүн төрөлхтний хэл ярианы үүсэл гарвалийн тухай “*On the Origins of Human Speech and Language*” хэмээх бүтээлдээ аман ярианы дуу авианаас гадна, хүний хувьслын судалгаа (study of human evolution), археологийн олдворууд (analyzing fossils and other remains), хүний анатоми (body) болон генетикийн судалгаануудад (the study of genes) суурилж дуу авианы үүтгэлийг бичжээ. Хөөмийн үүслийг монголчууд домог зүй (*мифилогизм*), домог үлгэрээр тайлбарлаж ирсэн нь дээр дурдагдан буй онолын агуулгатай адил төсөөтэй бөгөөд байгаль, амьтдын дуу чимээг даган дуурайх дуу авиа болж үүссэний зэрэгцээ хорио цээр (*табу*), дом засал (*магия*)-ын хэлбэрээр зан үйлд оролцож иржээ. Ингэж тухайн нийгэм, цаг үеийн тусгалыг шингээж явсаар монгол хөөмийн хөгжлийн эхэн үеийн уран бүтээлүүд нь ерөнхийдөө язгуур ахуйд хандсан зан үйлийн шинж бүхий урын санг бүрдүүлсэн байдаг. Түүхэн зүйн үүднээс үзэхэд, хөөмийн урлаг бол ахуйгаас үүдэж, зан үйлийн шинжтэй уламжлагдан явсаар урлагийн төрөл хэлбэрийг олж хөгжсөн байна. Эдүгээд ч зан үйлийн хэв шинжийг илтгэсэн бүтээлүүд монгол хөөмийн урын санд цөөнгүй бий.

Энэ үйл явц нь Б.Малиновскийн дэвшүүлсэн “зан үйл бол хүмүүний соёлын зайлиггүй хэрэгцээ шаардлагаас үүдэж бий болсон” гэдэг санаатай ерөнхийдөө дүйж байна. Иймээс урлаг бол зан үйлээсээ, хүмүүний зан үйл нь урлагаасаа ангид оршдоггүй, харин ч өөр хоорондоо нарийн нийлэмжээр харилцан сүлэлдэж оршин байдаг онцлогтой. Нийгэм, ахуйн үйл явдал, түүний олон төрөл зүйл, үзэгдэл нь урлагт туссан байдаг.


Ерөөс урлаг дахь дүрийн амилан орших орчин ахуй нь бол түүнийг дагалдан үүсэж хөгжсөн зан үйлийн соёл юм. Өөрөөр хэлбэл, монгол хөөмийн уран дүрслэл илэрхийлэл нь зан үйлийнхээ анхдагч ахуйд төрж биеждэг гэж үзэж байна.

Судалгааны үр дүн

Хөөмийн урлаг Монгол орны баруун хязгаар, Алтайн уулын бүс нутгуудад нутаглан ирсэн тодорхой хэсэг ард түмний дунд тархан хөгжиж, уламжлагдан ирсэн түүхтэй. Баруун монголчуудын дунд, тэр дундаа Ховд аймгийн Чандмань сумын ард иргэдийн дунд аливаа зан үйлийг гүйцэтгэхдээ хөөмийлөхүйн үйлийн оролцоотой гүйцэтгэж ирсэн эртний ёс уламжлал хадгалагдан ирсэн. Тухайлбал, таван хошуу малын төл авхуулах малын уриа дуудлагууд, уул овоо, байгаль дэлхий, лусын эздийг аргадах, тахих, хүн ардын жилийн засал хийх зэрэг сүсэг бишрэлийн

томоохон үйл хэрэгт хөөмийн авиа эгшиг чухал үүрэг гүйцэтгэж ирсэн. Энэ нь хүн зон, байгаль дэлхий, мал ахуйгаа тэнгэр, лус, эздэд даатган залбирч буй эртний бөөгийн цалиг шүтлэгийн шинжийг хадгалсан байдаг. Нөгөө талаас хөөмийн авиа, ая эгшгээр мал ахуй, байгаль дэлхийтэй харилцах хэл, тэмдэг дохио (*симиотик*), арга ухаан (*метод*) болохын сацуу хүмүүний дуу хоолойгоор зан үйлийг амилуулж ирсний нэгэн тод илрэл болно.

Хөөмийлөхүйн үйл нь хүмүүний бие эрхтнээр дамжин илэрхийлэгддэг монголчуудын язгуур аман өв, ая аялгуу юм. Хүний өгүүлэхүйн эрхтэн нь ерөнхий бүтцийн хувьд өргөн цар хүрээг хамруулна. Хөөмийлөхүй нь үг, хэллэг цөөн, авиа авиалбар, ая аялгуу давамгайлдаг тул хэл болон амны хөндий, залгиурын эрхтэн зонхилж ажиллана. Хөөмийлөхүй нь хүний толгой, цээж, хэвлийн эрхтнүүдийг хамраасан өргөн цар хүрээнээс үүдэх бөгөөд тэр дундаа өгүүлэхүйн эрхтний шууд оролцоогоор үүсэн буй болдог ая аялгуу юм. Энэхүү бие эрхтэн тогтолцоогоор дамжин илрэхдээ хүний сэтгэл оюун, бодол ухамсар, санаатай зайлшгүй нөхцөлдөж, харилцан шүтэлцэж үйлдэгддэг байна. Хөөмийлөхүйн үйл нь шахаа, исгэрээ, хархираа гэсэн үндсэн төрлөөр байгаль ертөнц, мал ахуй, ан амьтадтай харилцах үүрэг зориулалттай байна.



Зураг 2. Хөөмийлөхүйн үйл, түүний бүтэц, үүргийн онцлог

Монголчуудын язгуур урлагийн арвин их өв сан бол тодорхой зохиосон зохиогч үгүй ард түмнээсээ эх авч хөгжиж ирсэн ерөнхий нийтлэг хандлагатай. Монгол хөөмийн ая, аялгуу, дуугаралтын техник, төрөл, ангиллаараа өөр хоорондоо ялгаатай. Зураг 2-т хөөмийн үндсэн төрлийг үүрэг зориулалтын үүднээс зураглан харуулав. Хөөмийлөхүйн үйл бол байгаль, ан амьтан, араатан жигүүртэн, мал ахуйтай салшгүй холбоотой хөгжиж ирсэн амин чанар одоо ч уламжлагдан иржээ. Энэ тухай өндөр уулын оройд гарч исгэрэн хөөмийлж, халуун

өдөр салхи гарган хөгжөөж сэрүүцдэг байсан хэмээх аман мэдээ баримт ч байна. Хөөмийн дуугаралтын арга технологи байгалийн дуу чимээнээс хэрхэн уялдан хөгжсөн талаар хөөмийч Д.Цэрэндаваа ярихдаа, “Монгол хөөмийн төрөл үүсэн бүрэлдэхэд байгалийн дуу чимээг чухал үүрэг гүйцэтгэсэн. Жишээлбэл, байгалийн салхинд үелэх хулс, нахиа, навчны чичирхийлсэн дуу чимээ, голын ус хөлдөх үеийн болон хавартаа хайлах үеийн нуурын буйлаан, янз бүрийн шувуудын чуулаан, шувуу шувуун дотроо “усны бух” гэж маш хүчтэй дуугардаг жижиг шувуу байдаг. Тэр шувууны дууг хүртэл дуурайн хөөмийлдөг арга барил байдгаараа хөөмийн бол үнэхээр гайхамшигтай байгалийн бүтээл юм” (Цэрэндаваа 2016) гэсэн байна.

Хөөмийч Н.Сэнгэдорж, “хөөмий нь хүний сэтгэлтэй их холбоо хамааралтай, сэтгэхүйн дүрслэл, тусгал болж илэрдэг зүйл юм. Тэр уулын цуурай, мал амьтныг шууд утгаар нь дуурайх бус сэтгэхүйдээ төсөөлж уран сайхны аргаар илэрхийлж гаргаж байгаа урлаг юм. Залуу цагт бол хүмүүсийн хэлснээр янз бүрийн ойлголтод итгэдэг байж. Нас ахихын хэрээр, сүүлийн үед бүр их бодогддог болоод байгаа юм, их нарийн сэтгэхүйн урлаг гэдгийг нь” (Сэнгэдорж 2017) хэмээсэн нь

	Зан үйл	Тайлбар	Хөөмийлэхүйн төрөл			
			Шаха а	Исгэрэ з	Хархираа	
1	Хорио цээр (taboo)	Цас хүслэн	Байгалийн гамшигт үзэгдэл	+	+	+
			Харуй бүрий (харансуй шөнө)	+	+	+
			Өдрийн цагт үйлдэх			
			Дулааны улирал үйлдэх			
			Хүйтний улиралд үйлдэх			
		Орон зай	Үхэл, жагнал тохиосон газар үйлдэх	+	+	+
			Найр наадам, олныг цэнгүүлэх үйлд зорилуудах			
			Чимээгүй орчинд үйлдэх			
			Чимээгүй орчинд үйлдэх			
			Эрэгтэй хүн үйлдэх			
			Эмэгтэй хүн үйлдэх	+	+	+
2	Засал, дом (magic)	Сайн, сайшааг болгон дуудах	Алтайн магтаал хайлалгүйгээр үйлдэх	+	+	+
			Байгалийг аргадах	+	+	+
			Буйж хийшиг, эд баялаг дудахад			
			Тайвшрал авах	+	+	+
			Амар амгалан эрүүл энх байлгахад			
			Төл мал ахуулах	+	+	+
		Мүү, мэрхэлэг хөөм зийлүүлэх	Үр хүүхэлгүй айлд үрийн заяаг дудахад			
			Ард түмэн зон олны заяа буяныг даатгах, жилийн засал болгох			
			Гай барилд, үхээрийн бузар, дэв, хоргодсон мүү бүхнийг арилгах			
			Байгалийн дуу чимээг даган дуурайх, Салхины сэргийлсэн, усны харгиа, хоржигноон, хад хасаан харгиа, цуурай, гол нууруудын цөн түрэх дуу чимээ гэх мэт	+	+	+
			Таван хошуу малтай харилцах, өөвлөх, тойглох, гуулгах,	+	+	+
			Зэрлэг ан амьтадыг даган дуурайх, бугын урамдаа, тарваганы хонхирлоо, шувуудын жиргээ, чонын улиан гэх мэт	+	+	+
3	Бэлгэдэл	Хүн-байгалийн харилцах дэх уялз бэлгэдэл				
		Хүн-мал ахуйн харилцах н дэлз уялз бэлгэдэл				
		Хүн-эрлэг ан амьтны харилцах дэх уялз бэлгэдэл				

Аристотелийн “Урлаг бол байгалийг дуурайхуйн үйл явц юм” гэсэнтэй илүү дүйж байна. Нөгөө талаас, хөөмийн урлаг бол монголчуудын ахуйн соёл, амьдралын бодит тусгалыг уран сайхны арга хэлбэрээр илэрхийлэх соёлын үзэгдэл бөгөөд энэ нь хөөмийн урын санд тод тусгалыг олж хөгжсөн.

Хөөмийн дуугаралтын техник, төрөл ангилал нь зан үйл, хорио цээр, домын соёлд тус тусын үүрэгтэй бөгөөд урын сангийн хувьд ч баялаг өв санг бүрдүүлж ирсэн байна. Хөөмийн уран бүтээлүүд 1950-аад оноос өнөөг хүртэл хөгжиж баяжсаар байна. Монголчууд хөөмийн авиа эгшгээр байгалийн дуу чимээ, жигүүртэн шувууд, ан амьтдын дуу чимээг даган дуурайж дуугаралтын техник, ая аялгууг баяжуулж ирсний зэрэгцээ ардын дууг аялгуулан хөөмийлж ирсэн онцлогтой. Бидний

судалгаанд хөөмийг шахаа, исгэрээ, хархираа гэсэн үндсэн гурван төрөлд авч үзэж байна. Дуугаралтын энэхүү арга төрлүүдээр муу муухайг хөөн зайлуулж, сайн сайхан зүйлийг даллан дуудах хорио цээр (taboo), дом засал (magic), бэлгэдэл (symbol)-ийн зан үйлүүдийг гүйцэтгэж иржээ.

Монгол хөөмий, тэр дундаа шахаа хөөмийн урын санг төлөөлөх түүхэн чухал уран бүтээл бол “Алтайн магтаал” юм. Ойрадын зарим туульчид тууль хайлахын өмнө Алтай, хангайнхаа бүхий л зүйлсийг магтан шүлэглэж, “Алтайн магтаал”-ыг хэлдэг заншилтай. Тиймээс “Алтайгүй тууль тууль биш, авгайгүй айл айл биш” гэдэг үг баруун монголчуудын дунд яригдаж ирсэн түүхтэй. Баруун монголчуудын баатарлагийн туулийн үндсэн шахаа суурь өнгө хөөмийн ая аялгуугаар илэрч байдаг онцлогтой бөгөөд ерөөс туульчийг туулийн баатрууд хийгээд Алтай дэлхийн эзэдтэй холбодог амин сүнс нь хөөмийн авиа эгшиг байх боломжтой юм. Энэ нь зан үйлийн хэлбэрээр илрэн нотлогдож байна.

Хөөмийн урлаг анх мэргэжлийн тайзнаа, ард түмний сонорт хүрэхдээ, “Алтайн магтаал” бүтээлээр эгшиглэсэн бөгөөд 1954 онд С.Цэдээ, 1955 онд Г.Чимиддорж нар Д.Лувсаншаравын найруулгаар бүтээгдсэн “Алтайн магтаал”-ыг анх тайзнаа исгэрээ хөөмийгөөр хөөмийлсөн түүхтэй. Энэ тухай МУҮТА-т хадгалагдаж буй Д.Лувсаншаравын хувийн хөмрөг дэх 1954 оны “Ховд аймгийн Хөгжимт драматик театрын жүжигчид, сайн дурын уран сайханчдын урлагийн 10 хоногт тоглох концертын хөтөлбөр” (МУҮТА. х.545, Д.01, хн.85) зэрэгт тэмдэглэгдэн үлджээ.

1953 оны 04 дүгээр сард хуралдсан МАХН-ын №30/53 тоот, “Аймгуудад сайн дурын уран сайхны үзлэгийг явуулах тухай” тогтоол гарсан байдаг. Энэхүү тогтоол нь язгуур урлаг, тэр дундаа монгол хөөмийг шинэ шатанд гаргаж ирэх нөхцөл боломжийг хангаж өгсөн юм. Тухайлбал, аймгуудын **ардын авьяастан**, уран бүтээлчдийн урлагийн үзлэгийг жил бүр Улаанбаатар хотноо зохион байгуулах ажил явагдаж эхэлсэн. Улмаар, “1954 оны III улиралд Ховд аймгийн театр, сайн дурын уран сайханчдын үзлэгийн 10 хоногийг Улаанбаатар хотод явуулжээ. Энэ урлагийн 10 хоногийн хүрээнд Ховд аймгийн олон үндэстний дуу бүжиг, мөн орос ардын зөвлөлтийн дуу, хөгжмийг тоглосон байна” (Пунсалдулам 2018, 229). Энэ тухай МУАЖ Б.Зангад, “1954 оны Наймдугаар сард Ховд аймгийн соёлын өдрүүд Улаанбаатар хотод зохион байгуулагдсан юм. Энэ арга хэмжээн дээр тоглогдох нутгийн зохиолчдын уран бүтээлүүд их хэрэгтэй болсон., ...үнэнхүү олон ястны өлгий учраас гаргаж байгаа уран бүтээлийн чанар чансаа өндөр байсан. Тухайлбал, “Алтайн магтаал”-ыг Д.Лувсаншарав багш олон хоолойд найруулж тавьсан. Ховд аймгийн Чандмань сумын уугуул С.Цэдээ гэдэг хүн Төв театрын тайзан дээрээс хөөмий хэмээх сонсголонтой урлагийг нийслэлчүүдэд анх сонордуулсан нь их өвөрмөц болсон” (Зангад 2017) хэмээн дурсан ярьжээ. Ийнхүү нүүдэлчин монголчуудын язгуур урлагийн нэгэн өвөрмөц төрөл болох хөөмий урлаг ардын хэлбэрээс тайзны хэлбэрт шилжиж, 1954 онд эгшиглэж байсан түүхтэйг дээрх баримтууд илхэн харуулна.

Энэ тухай хөөмийч Д.Цэдээгийн хүү Ц.Жанчив дурсахдаа, “Ховд аймгийн соёл урлагийн 10 хоногийн үйл ажиллагаа Улаанбаатар хотод зохиогдох үеэр хөгжмийн зохиолч Д.Лувсаншарав, найруулагч Л.Ванган нар ирж ажилласан бөгөөд концертын дунд “Алтайн магтаал”-ыг дан найрал хөгжмөөр хийсэн. Гэтэл тэр “Алтайн магтаал” дундуур аялгуу хэрэгтэй болсон шиг байгаа юм. Тэгээд энэ

дундуур юуг хэрхэн яаж оруулах вэ гээд хоорондоо ярилцаад сууцгааж байхад аав маань хэлсэн байгаа юм. “-Багшаа би хоолойгоороо нэг ийм хөөмийн аялгуу дуугардаг. Та нэг үзэхгүй юу” гээд, аав маань хөөмийлж үзүүлсэн байгаа юм. Д.Лувсаншарав багш сонсоод, “-энэ их сонин аялгуу байна” гээд нөгөө “Алтайн магтаал” дахь дан найрал дотроо оруулж чимээд ингээд тайзнаа гарсан түүхтэй юм билээ. Ховд аймгийн Чандмань сумын Цагаан гол гэдэг газар амьдарч байсан, одоогийнхоор бол хөөмийч гэж дуудах эрхтэй Чулуун гэж хүндтэй хөгшин байсан юм билээ. Тэр хүн л анх хөөмийн аялгуу гаргадаг байсан гэж аав минь ярьдаг байсан. Аав минь тэр хүнийг дуурайж бүсээ, аягаа, алгаа бариад байгалийн дуу чимээ болох салхи шуурга, шувуудын жиргээг дагаж оролдож, нутгийн хэдэн залуучууд хөөмий гэдэг зүйлийг анх сурцгаасан гэж ярьдаг даа” (Сарантуяа 2016) хэмээн ярьсан нь эдүгээ алтан сан хөмрөгт үлджээ. Үүний дараа 1955 онд зохион байгуулагдсан Дэлхийн залуучууд, оюутны V фестивалд Ганжуурын Чимиддорж “Алтайн магтаал” бүтээлээр оролцож, дэлхийн сонорт дахин хүргэсэн байна. Энэ тухай МАХН-ын Төв хорооны хурлын 1955 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн №32 тоот тогтоолын “Дэлхийн залуучууд, оюутны V фестивалд бэлтгэх тухай” хэсэгт: 1.Ардын дуу, дуу бүжгийн ансамблийг шилдэг авьяастан залуучуудаар нөхөн хангахыг V фестивалд бэлтгэх Монголын хороонд зөвшөөрсүгэй. Ансамблийг 40 хүнтэй хорын групп, 20 хүнтэй танецын групп..., ажлыг нөхөр Ядамсүрэнд даалгасугай” (МУҮТА 1955, 1) гэж тэмдэглэжээ. Тус баримтын хавсралтад, “Дэлхий дахины залуучууд, оюутны нөхөрлөл, энх тайвны тавдугаар фестивалд монгол залуучуудын тоглох концертын программ 1-р хэсэг. Ганжуурын Чимиддорж², нас-24, басы хоолой-Алтайн магтаал” (МУҮТА 1955, 33-66) гэж бичсэнээс үзэхэд тус наадамд хөөмийн төрлөөр нэг л бүтээл тус концертод тоглогдсон байна. Г.Чимиддорж хөөмийн эрдмийг С.Цэдээгээс суралцаж эзэмшсэн хэмээн ахмад буурлууд өдгөө дурсдаг.

Түүнчлэн 1956 онд “Монгол кино үйлдвэр”-ээс Ц.Зандраа, Э.Оюун нарын зохиол, Э.Оюуны найруулга, “Манай аялгуу” хэмээх уран сайхны дуулалт киног бүтээсэн билээ. Тус кино нь манай алтан үеийн уран бүтээлчдийн хамтран бүтээсэн үндэсний хэв шинжтэй давтагдашгүй, өвөрмөц бүтээл юм. Кинонд “Алтайн магтаал” бүтээлийг Улсын хөгжимт драмын театрын дуучид аялгуулан дуулж, дууны дунд болон төгсгөл хэсгүүдэд хөөмийч С.Цэдээ исгэрээ хөөмийгөөр аялгуулан хөөмийлж, чимэглэж өгсөн нь тухайн бүтээлийн язгуур шинжийг илүүтэй тодотгож өгсөн байдаг. Ийнхүү монгол хөөмий анх удаа тайз дэлгэцийн бүтээлд эгшиглэж, олны хүртээл болсон түүхтэй. Түүнээс хойш төрөн гарсан бүхий л цаг үеийн хөөмийчдөөс “Алтайн магтаал”-ыг магтаж, хөөмийлөөгүй хөөмийч үгүй гэж хэлэхэд хилсдэхгүй. Эндээс үзэхэд, монгол ая эгшгийг дэлхийн сонорт хүргэсэн анхдагч уран бүтээл, хөөмийн урын сангийн язгуур эх үүтгэл нь “Алтайн магтаал” байжээ.

1954-1989 оны үед гарч ирсэн хөөмийн уран бүтээлчдээс нэрлэвэл, Д.Сундуй, Н.Сэнгэдорж, Э.Тойвгоо, Д.Цэрэндаваа, Т.Ганболд, Л.Базарваань, Б.Папизан,

² Зарим ном товхимолд Г.Чимиддорж хэмээн бичигдсэн байна. Зохиогч УТА-ын баримтуудад бичигдсэний дагуу Г.Чимиддорж гэх нэрээр тэмдэглэв.

Р.Даваажав, Б.Одсүрэн нарын хөөмийчдийг дурдаж болно. Харин 1990-2004 онд Т.Гэрэлцогт, А.Лхагваа, Д.Хосбаяр, Ж.Мөнхбат, Э.Сандагжав, С.Зулсар, Г.Алимаа, Н.Наранбадрах, С.Загд-Очир, Н.Ашид, Б.Болд-Эрдэнэ, Ч.Бат-Оюун зэрэг хөөмийчид, 2005 оноос хойш, Л.Лхамрагчаа, Г.Жамбаа, М.Саруултөгс, Ц.Цогтгэрэл, Ж.Мэндбаяр, Б.Энхбаяр, Х.Ганзориг, А.Ундармаа, П.Тэмүүжин, Т.Баянмөнх зэрэг олон арван залуу хөөмийчид төрөн гарч, хөөмийн урын сангийн хөгжилд чухал хувь нэмэр оруулсаар ирсэн. Эдгээр уран бүтээлчдийн урын сан дахь бүтээлүүдийн тоглогдох арга хэлбэр, шинж байдлаас ажиглахад, 1954-1989 оны уран бүтээлчид илүүтэй ардын богинын болон уртын дуунууд, аж байдлын шинжтэй аман аялгууг тоглох байдал давамгайлахаас гадна өөр өөрсдийн бодол, сэтгэмжээс хөөмийд зориулсан бүтээлүүдийг туурвиж байснаараа ихээхэн онцлогтой. Тухайлбал, Н.Сэнгэдорж “Жаргалтайн дэлгэр” уртын дууг өөрийн сэтгэмжээр урлаж, шахаа хөөмийн зохиомж болгон туурвисан. Мөн Д.Цэрэндаваа “Хөх салын гол” сэдэвт хосмолжин хөөмий буюу шахаа, исгэрээ хөөмийгөөр, И.Тойвгоо, “Тэс голын магтаал”, “Буурал тохой нутаг” гэх мэт өөр өөрсдийн хөөмийд зориулсан уран бүтээлийг туурвисан бөгөөд өнөөдөр ч уран бүтээлчид баяжуулан тоглосоор байна. Эдгээр ахмад хөөмийчдийн урын сан дахь бүтээлүүд нь монгол хөөмийн шахаа, исгэрээ төрлөөр хөөмийлж, язгуур хэв шинжээ хадгалан гоцлол төрлөөр хөгжиж ирсэн онцлог ялгаатай байна.

Харин 1990-2004 оны уран бүтээлчид өмнөх үеийн уран бүтээлчдийн адил ардын болон хөөмийд зориулсан зохиомжууд гоцлон тоглохын зэрэгцээ хамтлаг уран бүтээлчдийн бүтээлүүд эрчимтэй төрөн гарсан. Тухайлбал, “Алтай хангай” хамтлаг (1993), “Зүүдний говь”, “Монгол наадам”, “Онгод”, “Их монгол” гэх мэт, “Эгшиглэн” хамтлаг (1995) “Алтайн магтаал”, “Мандухай”, “Талын салхи”, “Бөртэ хамтлаг”-ын “Алтайн магтаал”, “Говь”, “Жуурай гэлдэн”, “Трансмонголиа” хамтлаг (2005) “Татлагын холбоо”, “Жамух”, “Елхэндэг”, “Зүүдний говь”, “Алтайн оргил” хамтлаг (2004) “Чингис хааны магтаал”, “Дүнчүүр маань”, “Алтан ураг хамтлаг”-ийн “Хөх толботон”, “Ижий монгол” гэх зэрэг олон арван хөөмийд зориулсан бүтээл шинээр төрөн гарч чухам энэ үеэс хамтлаг уран бүтээлчдийн шинэлэг, орчин үеийн өвөрмөц уран бүтээлүүдээр монгол хөөмийн урын сан баяжиж эхэлсэн гэхэд болно. Тухайн үеийн хамтлагийн уран бүтээлчид дийлэнхийг мэргэжлийн хөгжимчид бүрдүүлж байв. Тэдний уран бүтээл монгол хөөмийн язгуур хэв шинж болох исгэрээ хөөмийн төрлөөс илүүтэй шахаа, хархираа төрлийн арга техникт тулгуурласан бүтээлүүд давамгайлж эхэлсэн. Иймээс энэ үеийн урын сангийн төлөв байдал язгуур хэв шинж ба орчин үеийн урлагийн хосолмол шинжийг илэрхийлсэн байдлаараа онцлог байна. 2005 оноос өнөөг хүртэлх хугацаанд хөөмийн хөгжилд шинэ эргэлт болсон зүйл нь Монгол Улс мэргэжлийн хөөмийч бэлтгэж эхэлсэн үйл явдал юм. Энэ нь өмнөх ардын шавь сургалтын хэлбэрээс танхимын сургалтад шилжиж, мэргэжлийн хөгжмийн онолын үүднээс монгол хөөмийг зааж сургах томоохон алхам байв. Энэхүү үйл явдал монгол хөөмийн урын санд чухал үүрэг гүйцэтгэсэн нь гоцлол хөөмийн төрөлд чухал тусгалыг олсон. Өмнөх цаг үеүдэд цөөн тоглогддог байсан гадаадын сонгодог уран бүтээлүүд хөөмийгөөр эгшиглэж, монгол хөөмийн урын сан сонгодог бүтээлээр баяжиж, дэлхий нийтэд монголын биет бус аман өвийг түгээн сурталчлахад чухал хүчин зүйл болсон. Тухайлбал,

Ц.Цогтгэрэл “Phantom Opera”, “O solo mio”, “Time to say goodbye”, “Monti Czardas”, М.Сапуултөгс “Sorento”, Ж.Мэндбаяр “Time to say good bye”, “El condor pasa”, Б.Энхбаяр “O solo mio”, “Time to say good bye”, “Sorento”, А.Ундармаа “El condor pasa”, “O solo mio” зэрэг мэргэжлийн хөөмийчдийн төлөөлөл дээрх сонгодог уран бүтээлүүдийг хөөмийлж урын сангаа баяжуулсан байна. Дээрх орчин үеийн төлөөлөлд багтах уран бүтээлчид нь гоцлол болон хамтлагийн төрлүүдээр ардын болон сонгодог бүтээлүүдийг тоглохын зэрэгцээ мөн хөөмийд зориулсан уран бүтээлийг ч мөн үл орхигдуулан, олон улсад сурталчлан таниулж, монгол хөөмийн урын санг дэлхийд гайхуулсаар явна. Үүнээс дурдвал, хөөмийч Ц.Цогтгэрэлийн “Алтай магтаал”, “Гарын арван хуруу”, “Цомбон туурайтай хүрэн”, “Навчтай мод”, “Говийн өндөр”, “Аранжидмаа”, “Эрдэнэ засгийн унага”, “Сэржиймаа” зэрэг ардын бүтээл нь Үндэсний их театрын болон түүний өөрийн урын санд хадгалагдаж байна. Мөн хөөмийч Б.Энхбаярын “Алтай магтаал”, “Дөрвөн настай халиун”, “Дөрвөн уул”, “Хэрлэн”, “Хонин жороо морь” гэх мэт бүтээлийг нэрлэж болно. Үүнээс үзэхэд, орчин цагт ч монгол хөөмийн урын сан ардын язгуур хэв шинжийг хадгалан үлдэж, шинэ залуу уран бүтээлчид үндэсний бүтээлүүдийг монгол хөөмийн дуугаралтын амин чанар болох исгэрээ хөөмийн арга технологиор өвлөн уламжилж яваа нь сайшаалтай. 2005 оноос хойш Домог, Хөсөгтөн, Дөрвөн бэрх, Алтай, Хү зэрэг язгуур болон орчин үеийн этник урсгал чиглэлийн хамтлаг уран бүтээлчид төрөн гарч, ардын дууны урын санг шинэ өнгө аясаар туурвихын зэрэгцээ, түүхэн сэдэвт шинэ бүтээлүүдээр монгол хөөмийн урын санг бүрдүүлжээ.

Монгол хөөмийн урын санг ерөнхийд нь авч үзэхэд, тэдгээр хөөмийчдийн хөөмийлөх арга барил, ур чадвар, урын сангийн байдлаас судлан үзэхэд, исгэрээ, шахаа хөөмийн арга техник зонхилжээ. Хөөмийч бүр өөр өөрийн байгалиас заяасан өвөрмөц дуу хоолой, мэдрэмж, тембр, арга техниктэй байна. Аливаа туульд тогтсон, хэвшмэл шүлэг, үг гэж үгүй. Тууль хайлахад туульчид нэг туулийг өөр хоорондоо харилцан адилгүй, давтагдашгүй өнгө аясаар хайлдаг шиг хөөмийн дуурьсал, чимэг, нугалаа, арга техникүүд нь тухайн хөөмийчийн төрмөл авьяас, ур чадвар зэргээс ихээхэн шалтгаалж тоглогддог. Тиймээс хөөмий бол сэтгэлгээний урлаг юм. “Алтайн магтаал”-ыг дээрх хөөмийчид өөр, өөрийн өнгө аясаар чимэг нугалаа гаргаж, зарим үедээ шингэн цээл хоолойгоор дуулалттай хөөмийлөх бөгөөд үндсэн аялгуу нь шахаа хөөмий дээр суурилж гүйцэтгэдгээр онцлогтой.

“Алтайн магтаал”-аас гадна, шахаа хөөмийн төрлөөр Увс аймгийн хөөмийч, МУГЖ Э.Тойвгоо “Буурал тохойн нутаг” хэмээх магтаалыг товшуур хөгжмийн эгшигт үг аялгуутай аялгуулан тоглосон байдаг. Тэрээр:

[Ээ хээ], Сэр сэр [салхин жавартай]

Сэнсэн [ногоон шугуйтай]

[Сэрвээ алтан элстэй]

Сэтгэл [сэргээх] агаартай

Айхан тохой нутаг минь

Аав л ээжийн нутаг аа хэмээн шахаа хөөмийн өнгөн дээр үгээ хэлээд, үргэлжлүүлэн исгэрээ хөөмийгөөр чимэглэн уянгалуулж, бадаг хооронд дахилт хэлбэрээр аялгуулан хөөмийлжээ. Харин Увс аймгийн Тэс сумын ардын авьяастан А.Лхагваа хөөмийлөхдөө

[Зээ] ээ сэр сэр сэр сэр [салхилсан]

Сэнсэн [улаан элстэй]

Сэтгэл [аргадах] агаартай

Айхан тохой нутаг минь

Аав л ээжийн нутаг аа хэмээн мөн адил шахаа хөөмийгөөр аялгуулан хэлж, исгэрээ хөөмийгөөр чимэглэн тогложээ. Эдгээрээс хөөмийчийн тухайн цаг үеийн үг сонголт, амьсгааны хуваарилалт зэрэг нь өөр хоорондоо харилцан адилгүй байгаа нь дээр тэмдэглэснээр ажиглагдаж байна. Үүнээс үзэхэд, ерөөс хөөмийн бүтээлүүд тухайн хөөмийчийн дотоод мөн чанараас илэрхийлэгдэхдээ ая аялгуу, чимэг нугалааны хувьд өөр хоорондоо адилгүй, үг хэллэг, шүлэг найруулга нь тогтсон загварт баригддаггүй, харин нэгэн утга агуулгад зангидагдаж бүтээгддэгээр өвөрмөц байна. Иймд аливаа хөөмийчдийн ур авьяас, соёл сэтгэлгээний онцлогоос хамаараад ямарваа нэг уран бүтээл өөр хоорондоо харилцан адилгүй байх төдийгүй тухайн хөөмийч хоёр өөр цаг хугацаа, орон зайд туурвисан бүтээл, туурвилууд ч өөр хоорондоо яг адил байх боломжгүй юм. Энэ нь утгаа соёлын анхдагч хэлбэр болох зан үйлийн шинжтэй зүй ёсоор хамаарч байна. Монгол хөөмийн энэ язгуур, амьд үнэт чанар нь байгаль дээр илүүтэй сэргэж, илрэн биежиж зан үйлийн шинжээр хадгалагдан үлдсэн, өнөөгийн соёл иргэншилт орчин нөхцөлд урлагийн төрөл хэлбэрээр нийтийн дунд баяжин хөгжиж иржээ.

Ахмад хөөмийчдөөс Д.Сундуй, Т.Ганболд, Н.Сэнгэдорж, И.Тойвгоо, Д.Цэрэндаваа, Б.Папизан, Л.Базарваань нарын хөөмийчдийн уран бүтээлийн цомог, Монголын радиогийн алтан сан хөмрөг, Кино гэрэл зургийн архив зэрэгт хадгалагдан үлдсэн дуун болон дүрс бичлэгүүд эдүгээ хөөмийн уран бүтээлчдийн урын санг судлан шинжлэхэд чухал хувь нэмэр оруулж байна.

Хөөмийч Д.Цэрэндаваагийн 1983 оны “Бүх ард түмний язгуур урлагийн их наадам”-аар анх тайзнаа тоглож, нийтийн хүртээл болгосон “Хосмолжин хөөмий”-н арга барил нь шахаа хөөмийн суурь дээр тоглогддог. Түүний урын санд, “Хүрэн жороо морь”, “Монгол гэрийн магтаал”, “Дөрвөн настай халиун”, “Дөрвөн уул” зэрэг монгол ардын дуунууд, “Хөөрхөн халиун”, “Тоорой банди”, “Эрдэнэ засгийн унага”, “Өнчин цагаан ботго” зэрэг монгол ардын уртын дууг шахаа хөөмийн суурь дээр үгтэй хоршуулан дуулаад, хуур болон товшуур хөгжим дээр исгэрээ хөөмийгөөр чимэглэж хөөмийлсөн байна. Мөн хөөмийч Н.Сэнгэдоржийн урын санд “Хүрэн жороо морь”, “Дөрвөн уул” гэх зэрэг монгол ардын дуу, “Жаргалтайн дэлгэр” монгол ардын уртын дууг дан шахаа хөөмийн суурин дээр үгтэй аялгуулан хөөмийлсөн зэргээс үзэхэд шахаа хөөмий нь монгол хөөмийн урын санд чухал байр суурьтай болохыг илтгэнэ.

1990-ээдоноос зарим уран бүтээлчид нэгдэж, ардын урлагийн хамтлаг байгуулан европын орнуудад тоглолт хийж эхэлцгээсэн. Энэ үед хамтлаг, уран бүтээлчид нэмэгдэхийн хэрээр уран бүтээл, урын сангийн баяжилт сайжирсан. Өмнө зонхилж байсан ардын хэв маяг, донж, маниарууд шинэ хөгжмийн урсгалуудтай харилцан сүлэлдэхийн сацуу ардын урын сангийн арвин нөөц боломжид тулгуурлан үндэсний хэв маягийг орчин үетэй хослуулах арга техникийг нэвтрүүлж эхэлсэн байна. Европын орнууд руу гарч тоглолт хийж байсан залуучууд ихэнх нь хөгжимчин залуус байв. Тэд морин хуур, үндэсний хөгжмөөрөө дэлхийн алдартай сонгодог

бүтээлүүд, ари, романсуудыг тоглохоос илүү ардын урлаг, хөөмийн урлаг гадаадад сонин, үзүүштэй, гайхамшигтай болохыг мэдэрч монгол ардын язгуур урлаг, өв соёлоороо бахархах сэтгэл төрсөн хэмээн дурсан ярьж байна. Тийм ч учраас тухайн үеийн хамтлагуудын уран бүтээлд дэлхийн сонгодог хөгжмийг хөөмийлсөн бүтээл харьцангуй хомс байгаа нь анзаарагдаж байна. Тухайлбал, 1990-ээд оны эхээр байгуулагдсан “Алтай хангай” (1993), “Эгшиглэн” (1995), “Алтайн оргил”, “Алтан ураг”, “Домог” зэрэг хамтлаг шахаа болон хархираа хөөмийг хөгжмийн орчин үеийн урсгалуудтай хослуулан уран бүтээл туурвиж байв. Тухайлбал, “Алтай хангай” хамтлагийн бүтээсэн “Хэцүүм лоо” хэмээх бүтээл бол дан шахаа хөөмийн арга техникээр үгтэй аялгуулж хөөмийлсөн байна. Энэ үеийн гоцлол төрлийн уран бүтээлчид нь ихэвчлэн хөөмийн урлагаар дагнасан, мэргэшсэн хөөмийчид байсан бөгөөд дан шахаа гэлтгүй хөөмийн бүхий л төрлөөр уран бүтээлээ туурвидаг байв.

Орчин цагийн монгол хөөмийн шахаа төрөлд “Хөсөгтөн” хамтлаг гол үүрэг гүйцэтгэсэн юм. “Хөсөгтөн” хамтлаг 2009 онд анх удаа шахаа хөөмийнөөс таван өнгө салгаж /акабелла/ дуугарсан “Тэс голын магтаал” хэмээх томоохон уран бүтээлээ олны хүртээл болгосон. Мөн шахаа хөөмийгөөр голлон уран бүтээл туурвидаг “Алтай” хамтлагийг дурдаж болно. Үүнээс үзэхэд, шахаа хөөмийн төрөл нь уул овоо тахих, байгаль дэлхийг аргадах, баатарлагийн туульс хайлах зэрэг зан үйлийн шинжтэй бүтээлүүдэд түлхүү илэрдэг бол исгэрээ хөөмийгөөр монгол ардын богинын болон уртын дууг аялан хөөмийлөх, бороо хур, салхин сэвэлзээг урин дуудах зэрэгт бэлгэдэн хөөмийлж ирсэн уламжлалтай. Монгол хөөмийн урын сан дахь бүтээлүүдээс үзэхэд, 1950-1990-ээд оны үед монгол хөөмийн тоглолтын үндсэн арга техник исгэрээ хөөмий байсан бөгөөд энэ нь бусад угсаатнаас ялгарах гол онцлог болно. Исгэрээ хөөмий буюу Алтайн шингэн хөөмий бол хөөмийчөөс хүч, ур авьяас шаарддаг хүнд төрөл юм. Харин хархираа хөөмийгөөр уул усны чимээ, сүр хүчийг бэлгэдэн хөөмийлөх, малын уриа дуудлага болон зарим туулиудад оролцож ирсэн бөгөөд орчин цагт хөгжмийн урсгал чиглэлүүдтэй хамсран тоглогдож байна.

Хэлэлцүүлэг

Хөөмийн урлагийг зөвхөн урлагийн төрөл хэлбэр мэтээр ойлгож, тэмдэглэж ирсэн нь нийтлэг. Хөөмийлөхүйн үйлийн үүсэл гарваль, түүхэн зүйн судалгааг хийхэд анхдагч эх сурвалж, арга зүй нь хөөмийн урын сан бөгөөд түүнийг судлан сурвалжлах, төрөл ангилал, арга техникийн судалгааг нарийвчилж хийх нь чухал юм. Монгол хөөмийн байгаль дэлхийг аргадсан тахилын шинжтэй, цээрлэж домнох зан үйлийн дэг ёстой болохыг илтгэх урын сангийн чухал төлөөлөл бол “Алтайн магтаал” билээ. “Алтайн магтаал” нь угтаа баруун монголчуудын баатарлагийн хөлгөн их туульсын урьтал үг, лус савдаг шивдгийг аргадан тайтгаруулж заавал хэлэх ёстой уул усны хэл дохио, ая эгшиг болдгоор онцлог.

Дүгнэлт

Монгол хөөмийн урын сан дараах онцлогуудтай байна.

Монгол хөөмийн урын сангийн хөгжил нь байгаль, нийгэм, соёлын орчны нөлөөн дор үүсэж, бүтээгддэг амьд зүй тогтол бүхий биет бус соёлын аман өв юм. Чингэхдээ хүн төрөлхтний хөгжлийн эрт үеэс өнөө цаг хүртэлх хугацаанд монголчуудын байгаль, дэлхийтэй харилцах арга ухаан бүхий соёлын үйл хэргээс зан үйлийн хэв шинж бүхий урлагийн төрөл хэлбэр болтол хөгжиж ирсэн онцлогтой байна.

Хөөмийлөхүйн үйл нь өөрөө хүний оюун мэдрэмж, сэтгэхүйгээр илэрхийлэгдэх урлахуй юм. Энэ нь хүн өөрийн дотоод мэдрэмж, тархи оюунд үүссэн оюун санааны илэрхийллийг уран сайхны аргаар тухайн цаг хугацаа, орон зайд давтагдашгүй байдлаар хөг аялгуу, эгшиг авиаг дуурьсгах нь хөөмийлөхүйн үйл болж байна.

Хөөмийн урлагийг байгаль, хүрээлэн буй орчноос шууд хамааралтай, динамик шинж чанар бүхий системлэг соёлын өв гэж үзэж болно. Нөгөө талаас хөөмий нь “урлаг” хэмээх төрөлд хамаарахаасаа өмнө монголчуудын амьдралын хэв маягаас үүдсэн соёлын хэлбэр, үйл ажиллагаа, тэмдэг дохио бүхий зан үйлийн шинжтэй байсан байна. Аажимдаа уран сайхны хэлбэр, төрхийг олж хөгжиж, эдүгээ язгуур урлагийн төрөл жанр болж бүрэлдэн тогтсон байх бүрэн үндэслэлтэй юм.

Монголчуудын сав шимийн ертөнцийн мөн чанарыг таних, аргадан дээдлэх, амьдрах арга ухаанаас хөөмийн үйл үүдэж, түүний мөн чанарын илрэл нь хүний дуу хоолойгоор амилан биежиж ирсний бодит тусгал нь хөөмийн урын сан юм.

Монгол хөөмийн урын сан дахь бүтээлүүд нь шахаа, исгэрээ, хархираа гэсэн үндсэн гурван төрөлд хамаарах бөгөөд гүйцэтгэж буй уран бүтээлчийн сэтгэмж, мэдрэмж, арга туршлагаас шалтгаалан тоглолтын арга техникүүд харилцан адилгүй илэрнэ.

Хөөмийлөхүйн үйл нь тухайн хөөмийчийн бие, хэл, сэтгэлээр илэрхийлэгдэн гарахдаа үг хэллэг, хөөмийн чимэг нугалаа нь тухай хөөмийчийн ур авьяас, арга туршлагаас хамаарч харилцан адилгүй, харин үндсэн ая аялгууны хэлбэрийг тогтвортой хадгалж ирсэн байдал ажиглагдаж байна.

Монгол хөөмийн урын сан тоглогдох арга барилын хувьд, 1950-аад оноос 1990 оныг хүртэл шахаа, исгэрээ голлосон, гоцлол уран бүтээлүүд зонхилж байв. Урын сангийн дийлэнх нь ардын уртын болон богинын дуунуудаас гадна ахмад хөөмийчдийн хөөмийд зориулсан бүтээлүүд эзэлж байсан тэдгээр нь исгэрээ хөөмийн арга барилаар тоглогдож ирсэн язгуур хэв шинжтэй байв. 1990-ээд онд гарсан нийгмийн өөрчлөлтүүдээс шалтгаалж, хамтлаг уран бүтээлчид олноор гарч, хамтлаг уран бүтээлийн урын сан эрчимтэй хөгжиж, олон улсад монгол хөөмий танигдаж, хөгжих боломж нэмэгдсэн. Үүнээс үүдэж хөөмийн бүтээлүүд дан ганц ая аялгуугаар бус үг, аялгуу хамсарсан шахаа болон хархираа хөөмийн бүтээл, урын сан өргөжиж эхэлсэн гэж үзэж болно.

Үүний зэрэгцээ орчин үеийн хөгжмийн урсгал чиглэлийн хөгжлийг дагаж, монгол хөөмийн язгуур шинжийг илтгэх Алтайн шингэн хөөмий буюу исгэрээ хөөмийн төрөл, арга техник үндсэн шинжээ алдах, хөөмийлөхүйн үйл язгуур зан үйлийн шинжээс холдож уран сайхны хэлбэрээр нийтэд ойлгогдох байдал бий

болж байна. Тиймээс аман соёлын эртний хэлбэр болох хөөмийлөхүйн үйлийг уран бүтээл, урын сангаар дамжуулан соёлын хүн судлалын үүднээс зан үйл, соёлын утга тайлал, бүтэц, үүргийн судалгааг нарийвчлан судлах шаардлагатай.

Ашигласан материалын жагсаалт

Монгол хэлээр:

Бадраа, Ж. 2017. *Ардын урлаг судлал*. Улаанбаатар.

Балхаажав, Ц., Лувсанцэрэн, Г., Норовсамбуу, С., Нямдорж, Ү., Содномгомбо, Д. 1990. *Философийн толь*. Улаанбаатар: УХГ.

Батчулуун, Лүнтэн. 2018. *Монголын дүрслэх урлагийн нэвтэрхий толь*. Улаанбаатар: Сэлэнгэ пресс.

Бум-Очир, Д., Мөнх-Эрдэнэ, Г. 2012. *Нийгэм, соёлын хүн судлалын онолын үүд*. Улаанбаатар: Адмон.

Жанцанноров, Нацаг. 1996. *Хөгжмийн онолын нэр томъёоны хураангуй тайлбар толь (Орос-монгол, монгол-орос)*. Улаанбаатар.

Пунсалдулам, Б. 2018. *Шинэ соёл монголд төлөвшсөн түүх (XX зуун)*. Улаанбаатар: Соёмбо принтинг.

Энэбиш, Ж. 2017. *Монгол хөгжмийн их нүүдэл-I*. Улаанбаатар.

Гадаад хэлээр:

Courtenay, Jan Baudouin de. 2024. <https://www.polilingua.com/blog/post/theories-of-languages-origin.htm>.

Андреева, Н. С. 2018. “Магия - ритуал - миф теориях культуры (Дж. Фрезер и Малиновский).” *Вестник научный журнал, Ленинградского государственного университета*: 83.

Архивын баримт:

Монгол Улсын Үндэсний төв архив /МУҮТА. *Д.Лувсанишаравын хувийн архив 1954. х.545, д.01, хн.85*.

Монголын радиогийн алтан сан хөмрөг:

Сарантуяа, Н. (зох.). 2016. “Хөөмийч С.Цэдээгийн тухай.” 2024.07.22. Монголын Радиогийн Алтан сан хөмрөг.

Аман ярилцлага:

Сэнгэдоржийн Нанжидтай хийсэн Монгол хөөмийн тухай ярилцлага. Улаанбаатар, 2017.07.17.

Дашдоржийн Цэрэндаваатай хийсэн Хөөмийн түүхэн хөгжлийн тухай ярилцлага. Улаанбаатар, 2016. 08 13.